

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Байршил:

Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/84 дүгээр албан бичгээр ирүүлсэн саналын дагуу Хэрлэн сум, 5 дугаар баг САА-н ногооны талбайд хаягт байршилтай 0000032825 дугаар гэрчилгээтэй газарт жимс, жимсгэний суулгац үржүүлгийн төвийг байгуулна.

ЖИМС ЖИМСГЭНИЙ СУУЛГАЦ ҮРЖҮҮЛГИЙН ГАЗАР БАЙГУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

№	Хийгдэх ажлын нэр	Тендэрт оролцогчийн санал
Нэг. Үндэслэл, стандарт		
1.1	Энэхүү ажлыг "Жимс жимсгэний үржүүлгийн газар. Ерөнхий шаардлага MNS 6876:2020 стандарт"-ын дагуу хийж гүйцэтгэж хүлээлгэн өгнө.	
Хоёр. Хийх ажлын хэмжээ		
2.1	Нийт талбай. Суулгац үржүүлгийн төвийг 3 га-аас доошгүй талбайд байгуулна.	
2.2	<p>Байгуулах эх цэцэрлэг: Суулгац үржүүлгийн төв нь тухайн бүс нутгийн уур амьсгалын онцлогт үндэслэн гарал үүсэл тодорхой алим /торниун болон бэсрэг/, чацаргана, үхрийн нүд, интоор, лийр, чавга, далан хальс, интоор, бөөрөлзгөнө зэрэг 6-8 төрлийн жимс жимсгэний, 12-оос доошгүй сортын /Монгол улсад нутагшсан болон ирээдүйтэй сортоор батлагдсан/ 1500 ширхэгээс доошгүй суулгацыг тариалж суулгац үржүүлэх эх цэцэрлэг байгуулна. Нэг сортын жимсний суулгацын хэмжээ 30 ширхэгээс доошгүй байна. Суулгац үржүүлэх эх цэцэрлэг байгуулах суулгац нь гарал үүсэл тодорхой, ургамлын гарал үүслийн бичигтэй байна. Хэрэв нийлүүлэгч нь өөр эх үүсвэрээс худалдан авч нийлүүлэх бол тухайн этгээдтэй байгуулсан гэрээг ирүүлнэ.</p> <p>Нийт суулгацын 30-аас ихгүй хувьд нутагшиж батлагдаагүй боловч Монгол Улстай уур амьсгал ижил төстэй орноос импортлосон Монгол улсад ургах боломжтой гэж үзсэн сортын суулгац тариалж туршиж болно. Энэ тохиолдолд шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ, турших гэрээг Ургамал газар тариалангийн хүрээлэнтэй байгуулж, гэрээг ирүүлнэ.</p> <p>Эх цэцэрлэг бүхий суулгац үржүүлгийн төвийг стандартын дагуу байгуулах ба эх мод, байгууламж, зам талбай нь тэмдэг тэмдэглэгээ, пайзтай байна.</p> <p>Бойжуулгын талбай: 0.3 га-гаас доошгүй суулгац бойжуулгын талбайг стандартын дагуу бэлтгэсэн байна.</p>	
2.3	Хамгаалалтын ойн зурвас: "Жимс жимсгэний үржүүлгийн газар. Ерөнхий шаардлага MNS 6876:2020 стандартын 5.1.4-д заасны дагуу хамгаалалтын ойн зурвасыг салхины хөндлөн хоёр чиглэлд байгуулна.	
2.4	Ажлын байр: Судалгаа хийх, ажилчид байрлах 3x8 метр буюу гадна талдаа 1 хаалгатай, дотроо үүдний өрөө бүхий 2 хаалгатай, 2 өрөөтэй зөөврийн орон сууц суурилуулна.	



	Цахилгааны монтажтай холбох, гэрэлтүүлэгтэй болгох, халаалтын зуух, яндантай байна.	
2.5	Усалгааны сав: 20 тонноос доошгүй багтаамжтай ус нөөцлөх савыг 1 метрээс доошгүй өндөрт суурилуулна. Усалгааны савыг усны насос, дуслын усалгааны төхөөрөмж, суулгац үржүүлгийн моднуудтай холбосон автомат ажиллагаатай насостой байна.	
2.6	Дуслын усалгааны төхөөрөмж: Нийт эх цэцэрлэгийн талбайн жимсний мод, ойн зурвасны моднуудад дуслын усалгааны төхөөрөмж суурилуулж, усалгааны төхөөрөмжтэй холбосон байна.	
2.7	Суулгац үржүүлгийн хүлэмж: Суулгац үржүүлэх зориулалтын мананжуулах төхөөрөмж бүхий 6х20 метр хэмжээтэй 120 м2 талбайтай 2 иж бүрдэл нийлэг хальсан хүлэмжийг суурилуулсан байна.	
2.8	Жимс жимсгэний суулгац үржүүлгийн хашаажуулсан газрын цахилгаан шугамын эх үүсвэрээс зөөврийн сууц, усалгааны насос цахилгааны шугам холбох ажлыг хийх	
Ажлын явцын тайланг (фото зургийн хамт) 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор албан бичгээр болон bayanjargal@gmofa.gov.mn цахим хаягт ирүүлнэ, эцсийн тайланг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт болон bayanjargal@gmofa.gov.mn цахим хаягт ирүүлнэ.		

НИЙЛҮҮЛЭХ БАРААНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Нийлүүлэх барааны нэр	Тендерт оролцогчийн санал
1	Трактор: 50 мориноос дээш хүчтэй трактор, тус тракторт угсарч ажиллуулах модны нүх ухагч, анжис, сийрүүлэгч, борнойтой байна. Үйлдвэрийн 1 жилийн баталгаатай, дагалдах сэлбэг хэрэгсэлтэй байна.	
2	Багаж: Гар багаж /хүрз- 5 ш, секатор-2 ш, хайч-2 ш/, өвс хадагч 1 ширхэг /бензин мотортой/	
3	Монгол Улсад мөрдөгдөж буй "Зуны нийлэг хальсан хүлэмж Техникийн ерөнхий шаардлага" MNS 6636:2016 стандартын шаардлагыг хангасан суулга ц үржүүлэх зориулалтын мананжуулах төхөөрөмж бүхий 120 м2 талбайтай 2 иж бүрдэл нийлэг хальсан хүлэмж нийлүүлнэ.	
4	Алим /торниун болон бэсрэг/, чацаргана, үхрийн нүд, интоор, лийр, чавга, далан хальс, интоор, бөөрөлзгөнө зэрэг 6-8 төрлийн жимс жимсгэний, 12-оос доошгүй сортын /Монгол улсад нутагшсан болон ирээдүйтэй сортоор батлагдсан/ 1500 ширхэгээс доошгүй суулгацыг нийлүүлнэ.	
5	Хамгаалалтын ойн зурвас байгуулахад 2 төрлийн модны 400-гаас доошгүй суулгац нийлүүлнэ.	
6	Хэрлэн голоос ус татах насос, 20 тонноос доошгүй багтаамжтай ус нөөцлөх усалгааны сав нийлүүлнэ.	
7	Дуслын усалгааны төхөөрөмж нийлүүлнэ.	
8	15-20 кВт чадалтай синхрон дизель генератортой байх	



**Жимс, жимсгэнийн үржүүлгийн аж ахуйд ашиглах 50м.х-тэй
тракторын техникийн тодорхойлолт**

Ерөнхий үзүүлэлт: Дугуйт трактор, 50-60 м.х-тэй, хөдөлгүүр нь усан хөргүүртэй, кабинтай, дугуйн зүтгэх хэлбэр 4 х 4 байхыг шаардана. Үйлдвэрлэгчийн гарал үүслийг тодорхойлсон каталогийг ирүүлнэ.

Нарийвчилсан үзүүлэлт:

№	Үзүүлэлт	Захиалагчийн шаардлага	Нийлүүлэгчийн санал
1	Тракторын хүчин чадал м.х	50-60	
2	Хөдөлгүүрийн төрөл	дизель	
3	Цилиндрийн тоо	4-6	
4	Тахир голын эргэлтийн тоо	1700-2400 эрг/мин	
5	Хурдны хайрцагны дамжуулгын тоо	12+12	
6	Хурдны хайрцагны араг шилжүүлэгч	синхронизатортай	
7	Хурд	2-40 км/цаг	
8	Хүч сунгах голын эргэлт	540/1000 эрг/мин	
9	Дүүжин механизмын өргөх даац	1200 кг-аас багагүй	
10	Гидросистемийн шахах насосны бүтээмж	32-40 л/мин	
11	Дугуйн мөр хоорондын зай	1800-2200 мм	
12	Замын гэгээвч зай	305 мм-ээс багагүй	
13	Эргэлтийн радиус	3.6-4.0м	
14	Оврын хэмжээ	Урт 3.2-4.2м Өргөн 1.6-2.2м Өндөр кабинтай 2.5-2.9 м	
15	Дугуйн хэмжээ	8.3-20/14.9-24 үзүүлэлтээс багагүй.	
16	Жин	2400-2800 кг	
17	Цахилгааны систем	12 В хүчдэлд ажиллах асаалтын болон, гэрэлтүүлгий системтэй байна. Урд хойд гэрэлтүүлэг, дохионы гэрэл, оврын гэрэлтэй байна.	



Анжисны техникийн тодорхойлолт

Ерөнхий үзүүлэлт:

50 м.х тракторт угсрах зориулалттай, дүүжин анжис байна.

Нарийвчилсан үзүүлэлт

№	Үзүүлэлт	Захиалагчийн шаардлага	Нийлүүлэгчийн санал
1	Ажлын өргөн	0.7-1.1 м	
2	Хагалгааны гүн	25-30 см	
3	Ажлын хурд	3-7 км/цаг	
4	Корпусны тоо	2-3	
5	Жин	400-1200 кг	
6	Агрегатлах трактор	40-50 м.х	
7	Тракторт угсрах арга	Дүүжин, гурван цэгт холбоосоор	

Хэрлэн голоос жимс, жимсгэнийн үржүүлгийн талбайн усалгааны төхөөрөмжийн тодорхойлолт

Ерөнхий үзүүлэлт: Хэрлэн голоос ус татах насосоор жимс, жимсгэнийн талбайг услах усалгааны төхөөрөмжтэй байна.

Нарийвчилсан үзүүлэлт:

№	Захиалагчийн шаардлага	Үзүүлэлт	Нийлүүлэгчийн санал
1	Насосны шахах хоолойн диаметр, мм	100-120, ус нөөцлөх савыг дүүргэх холболттой байна.	
2	Насосны бүтээмж, л/мин	600-аас багагүй	
3	Усалгааны төхөөрөмжийн бүтээмж, га	3 га-аас доошгүй,	
4	Ус нөөцлөх савны багтаамж, тн	20 тн-оос доошгүй багтаамжтай ус нөөцлөх савыг 1м-ээс доошгүй өндөрт суурилуулна. Усалгааны савнаас дуслын усалгааны төхөөрөмжийг суулгац үржүүлгийн моднуудтай холбосон автомат ажиллагаатай насостай байна.	



**Жимсний модны титмийн доод хэсгийн хөрсийг сийрүүлж боловсруулах
сийрүүлэгч, борнойн техникийн тодорхойлолт**

Ерөнхий үзүүлэлт:

Жимсний модны титмийн доод хэсгийн рөрсийг сийрүүлж борнойдох зориулалттай сийрүүлэгч, борной байна. Жимсний талбайн хог ургамлыг устгана. 50 м.х тракторт угсрах зориулалттай байна.

Нарийвчилсан үзүүлэлт

№	Үзүүлэлт	Захиалагчийн шаардлага	Нийлүүлэгчийн санал
1	Ажлын өргөн	0.6-1.2 м	
2	Ажлын бүтээмж	0.3-0.6 га/цаг-аас доошгүй	
3	Ажлын хурд	3-7 км/цаг	
4	Боловсруулах гүн	3-12 см	
5	Хог ургамлыг устгах чадвар	90 хувиас багагүй байх	
6	Жин	500-1200 кг	
7	Агрегатлах трактор	40-50 м.х	
8	Тракторт угсрах арга	Дүүжин, гурван цэгт холбоосоор	



Дизель генераторын техникийн тодорхойлолт

Ерөнхий үзүүлэлт: 15-20 кВт чадалтай синхрон дизель генератор байна. Үйлдвэрлэгчийн каталоги, ашиглалт, аюулгүй ажиллагааны зааварчилгааг Монгол хэл дээр орчуулж ирүүлнэ.

Нарийвчилсан үзүүлэлт

№	Үзүүлэлт	Захиалагчийн шаардлага	Нийлүүлэгчийн санал
1	Хэвийн чадал	15-20 кВт	
2	Хамгийн их чадал	16-22 кВт	
3	Гаргах хүчдэл	220/400 В	
4	фазын тоо	3	
5	Гүйдлийн хүч	27-30А	
6	Хөдөлгүүрийн цилиндрийн тоо	2-4	
7	Асаалтын систем	12В цахилгаан стартер	
8	Түлшний зарцуулалт хэвийн горимд	3-5 л/цаг	
9	Хяналтын самбар	Гүйдлийн хүч, хүчдэл хэмжигчтэй	
10	Дууны хүч	90-95 дБ	



Хүйтэнд тэсвэртэй жимс жимсгэний суулгац үржүүлгийн хүлэмжийн тодорхойлолт

Нийлүүлэгдэх хүлэмж нь Монгол Улсад мөрдөгдөж буй "Зуны нийлэг хальсан хүлэмж Техникийн ерөнхий шаардлага" MNS 6636:2016 стандартын шаардлагыг хангасан 6х20 метр хэмжээтэй 120мкв талбай бүхий иж бүрэн /суулгац үржүүлгийн мананжуулагчтай/ 2 ширхэг хүлэмж байна.

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт <i>(Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)</i>	Санал болгож буй техникийн тодорхойлолт <i>(захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)</i>	Тайлбар <i>(дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)</i>
1.	<p>Барааны ерөнхий үзүүлэлтүүд</p> <p>1.1 Барааны нэр, модель</p> <p>1.2 Гарал үүсэл</p> <p>1.3 Үйлдвэрлэгчийн нэр, хаяг</p> <p>Үйлдвэрлэсэн он, сар, өдөр: 2024 онд үйлдвэрлэсэн байна.</p>		
2.	<p>2.1 Төрөл: Нийлэг хальсан бүрхүүлтэй, нуман оройтой, хавар-зун-намар ашиглагдах, хүнсний ногоо, жимс, цэцэг, эмийн ургамал тариалах, жимсний мод үржүүлгийн ажил хийх боломжтой хүлэмж байна.</p> <p>2.2 Хэмжээ: Өргөн нь 6 метр, урт нь 20 метр, өндөр нь 2,8 метрээс доошгүй байна.</p> <p>2.3 Иж бүрдэл: Хүлэмжийн цайрдсан ган хоолой бүхий их бие, нийлэг хальсан бүрхүүл, тэдгээрийг холбох, бэхлэх, зориулалтын /нийлэг хальс түгжигч, түгжигчийг холбогч, нийлэг хальс хавчигч, хоолой холбогч, хоолой бэхлэгч гм./ хэрэгслүүдтэй байна.</p> <p>2.4 Их бие буюу нуман нурууны ган хоолой нь 1.5мм буюу түүнээс дээш ханын зузаантай, диаметр нь 25мм буюу түүнээс дээш зэвэрдэггүй, цайрдсан гангаар хийгдсэн байна. Хөндлөн бэхэлгээний болон суултаас хамгаалсан ган хоолойнууд нь 1.2мм буюу түүнээс дээш ханын</p>		



<p>зузаантай, диаметр нь 25 мм буюу түүнээс дээш зэвэрдэггүй, цайрдсан гангаар хийгдсэн байна. Цайрын хэмжээ 300г/м² аас доошгүй байна.</p> <p>2.5 Босоо нуман тулгууруудын хоорондох зай :</p> <p>0.7 метрээс ихгүй байх ба хүчтэй салхинаас хамгаалагдсан хөндлөн бэхэлгээ нуруу 10 эгнээнээс доошгүй, 25см-ээс доошгүй зузаантай цас, 25м/сек-ээс доошгүй хурдтай салхийг тэсвэрлэдэг байна.</p> <p>2.6 Агааржуулагч: Хүлэмжийн хоёр хажуу тал уртын дагуу 0.8м метрээс багагүй, 1.2м ээс ихгүй өргөнтэй агааржуулалтын нээлхийтэй байна. Нээлхийг нээж, хаах механик төхөөрөмжөөр тоногдсон байна.</p> <p>2.7 Нийлэг хальс: -40-өөс +50 хэмд физик шинж чанараа алддаггүй, 0.10 мм-ээс дээш зузаантай, ашиглалтын хугацаа 2 жилээс доошгүй, хүлэмжийн зориулалттай байна. Энэхүү нийлэг хальс нь гурван давхраат бүтэцтэй (хэт ягаан туяаны хамгаалалттай, дулаан барих чадвартай, усан дусал үүсгэдэггүй) нарны гэрэл сайн нэвтрүүлдэг, тунгалаг нийлэг хальс байна. Салхины даац 15кг/м²-аас багагүй байна. Нийлэг хальс нь удаан жилийн эдэлгээтэй, полиэтилен (PE), этилен винил ацетат (EVA), Полиолефин (PO) нийлэг хальс байна.</p> <p>2.8 Хаалга: Хүлэмжийн нэг талдаа, шулуун ховилтой замаар роликоор гүйж нээгдэж хаагддаг хос хаалгатай байна.</p> <p><u>Мананжуулагч усалгааны төхөөрөмж:</u></p> <p>2.9 Төрөл: Нийлэг хальсан хүлэмжний мананжуулагч усалгааны төхөөрөмж</p> <p>2.10 Услах таримлын төрөл: Модны үр, цухуйц, тарьц, суулгац</p>		
--	--	--



<p>2.11 Услах талбайн хэмжээ:120м² талбай буюу 20м-ийн урттай, 6 метрийн өргөнтэй талбай</p> <p>2.12 Тарилтын схем:1.0-1.5 метр өргөнтэй 3-4 далан байгуулж, мөр хооронд 20-25 см үр тарих, мөчир тарихдаа мөр хооронд 20-30 см, ургамал хооронд 10-15см зайтай тарина.</p> <p>2.13 Иж бүрдлүүд: Ус шахах насос, шүүлтүүр, крант, мананжуулах услуур бүхий хошуу, түгээх, ус шахах хоолой болон тэдгээрийг хүлэмж болон хооронд нь холбох холбогч, бэхлэгч дамжуулагч, жийргэвч зэрэг эд ангиудтай байна.</p> <p>2.14 Мананжуулагч хошуу: Хуванцар материалаар хийгдсэн. Дөрвөн зүгт тоосруулах хошуутай, 3-5кг/см² хэмжээний даралтыг тэсвэрлэх. Усалгааны явцад болон усалгаа зогсоход усан дусал гоождоггүй клапантай байх.</p> <p>2.15 Ус дамжуулах хоолой: Полиетилен материалаар хийгдсэн, 0.7Мра-аас доошгүй даралтыг тэсвэрлэх, ажиллах даралт 3-5кг/см², гадаад диаметр нь 32.0 мм-ээс доошгүй, ханын зузаан 2.0мм-ээс доошгүй, ашиглалтын хугацаа 5 жилээс багагүй байх</p> <p>2.16 Ус шахах насос: Цахилгаан 220 вольтоор ажилладаг, фаз 50 Hz, 700 аас дээш ваттын чадалтай, оролт гаралтын хошууны диаметр 25мм-ээс багагүй, усны зарцуулалт 3,000 литр/цагаас багагүй, ус өргөх өндөр 55 метрээс дээш өндөр дагалтын усалгаанд зориулсан насос байна.</p> <p>2.17 Шүүлтүүр, крант: Түргэн цэвэрлэгч кранттай, шүүлтүүр нь дискэн, шүүгч торны</p>		
---	--	--



	хэмжээ 0.125мм-ээс дээшгүй байна.		
3	Дагалдах багаж, сэлбэг: 3.1 Үйлдвэрлэгчийн стандартын дагуу дагалдах сэлбэг, хүлэмж угсрахад зайлшгүй шаардагдах багаж, температур болон агаарын харьцангуй чийг хэмжигчтэй байна.		

